

ХЯТАД УЛСЫН БҮС НУТГИЙН АСУУДАЛ

С.Онон

Т.Арман

Б.Мөнхсарнай

Ц.Номин-эрдэнэ

БНХАУ нь Монгол улс, Орос, Хойд Солонгос, Лаосаас бусад өөрийн хөрш улс орнуудтай хилийн нутаг дэвсгэрийн маргаантай. Хилийн шугам, нутаг дэвсгэрийн маргаантай асуудлаас гадна бусад улс орнуудын газар нутагт шунасан Хятадын газар нутгийн санаархал гэсэн албан бус бодлого байдаг. Хятадууд хил залгаа том жижиг ихэнх улстай газар нутгийн маргаан хийсээр, тэр нь заримдаа хурцдаж, дайн байлдаан хүртэл гаргах шахдаг болсон. БНХАУ-тай хил залгаа улс орнуудын хувьд асар их болгоомжтой хандахгүй бол асуудал хүндэрч болзошгүй гэж эмээдэг ч улсынхаа хил хязгаарын бүрэн бүтэн байдлын төлөө бүгдийг хийж байгаа.

Хятадын газар нутгийн санаархалыг ил тодоор нийтэд тунхаглаж байсан хүн нь Мао Зэдун юм. Мао Зэ Дуны өөрийн болгох зорилготой байсан газар нутгийн жагсаалтад Бирм, Лаос, Энэтхэгийн хойд бүс нутаг, Непал, Бутан, Таиланд, Малайз, Сингапур, Киргиз, Монгол, Тайвань, өмнөд Казахстан, Афганистаны Бахдашан суурин, алс дорнодын зүүн өмнөдөөс Охотск хүртэлх нутаг бичигдсэн байсан.



Тайванийн асуудал

БНХАУ байгуулагдах хүртэл албан ёсоор Хятад улсад багтаж байсан Тайван арал одоо тус улсын хувьд маргаантай газар нутаг байдаг.

1949 оноос хойш Тайваний асуудал БНХАУ-ын хувьд байнгын маргаантай байсаар ирсэн. Тус улс нь 10 гаруй жил Хятадыг НҮБ-д төлөөлж байсан. Харин Тайван арал эх газрын бүрэн хараат улс хэмээгдэж газрын зураг дээр Хятадтай адил өнгөөр тэмдэглэгдэх болсон. БНХАУ сүүлийн хэдэн жил Тайван бол Хятадынх гэдгийг дэлхий нийтэд ойлгуулах томоохон шийдвэрүүдийг гаргасаар ирсэн. Тайван арлынхны хувьд эх газрын Хятадын нэг хэсэг нь Монгол Улс болон Оросын автономит Тува улс мөн хэмээн эдүгээ ч иймэрхүү газрын зураг хэвлэн тараасаар байдаг.



Өмнөд Хятадын тэнгис дэх маргаантай газар нутгууд

Хятадын өмнөд хэсэгт тэнгисийн эрэг дагуу оршдог бүлэг хэдэн арал байдаг. Тэдгээр арал болон ойр орчмынх нь газар нутгийг Өмнөд Хятадын далайн бүс хэмээн хятадууд ярьдаг. Гэвч тухайн бүс нутаг дахь бусад улс орнууд ч өөр өөрсдийн хэлээр тэрхүү нутгийг нэрлэж хилийн маргаанд оролцдог.

Энд Вьетнам, Малайз, Бруней, Филиппин гээд Зүүн Өмнөд Азийн хэд хэдэн улсын эрх ашиг огтлолцож байдаг газар болох Спартли арлууд, Параселийн арлууд болон Тонкийн булан оршино.

Вьетнам, Хятад хоёр 1979 онд эдгээрээс болоод жижиг хэмжээний дайн хүртэл хийж байсан. Энэхүү газрын ойролцоох усан доор ихээхэн хэмжээний байгалийн хий, газрын тосны нөөц байдаг бол усанд нь их хэмжээний загас агнуурын нөөц бий. Түүхчид, судлаачид ч энд тогтоосон хилийн зурвасын талаарх ойлголтыг нэг мөр болгож чаддаггүй. Энэ орчмыг аль нэг улс нь өөрийн эзэмшилдээ багтаахын тулд 100 гаруй жилийн турш маргалдсаар байгаа ба сүүлийн хэдэн жил БНХАУ бусдыгаа давамгайлахыг оролдож байна.



Вьетнам, Хятад улсын хооронд Өмнөд Хятадын тэнгисийн Парсел болон Спратлиарлын арлын эзэмшлийн асуудлаар олон жилийн турш маргаантай. Хэдийгээр маргаантай арлууд байнгын оршин суугчгүй, жижиг ч гэлээ эзэмшиж байгаа улсууд нь цэргийн хүч байрлуулах замаар бүс нутгийн далайн тээврийн гол замуудыг хянах боломжтой ба Ханой "манай эдийн засгийн онцгой бүс" хэмээдэг бол Бээжин "Хятадын нутаг дэвсгэр" гэж үздэг.



Өмнөд Хятадын тэнгист цэргийн хүчээр давамгайлах гэсэн Хятадын санаархлыг Вашингтон зогсоохын тулд Филиппин болон Вьетнамд цэргийн баазаа байршуулах, цаашлаад Лаос, Камбожийг талдаа татан оруулж Хятадын эсрэг өмнөд Азийн цэргийн эвсэл үүсгэхийг эрмэлзсээр ирсэн нь нууц биш. Энэ нь ч бодит байдал дээр эхнээсээ хэрэгжиж эхэлсэн.

Үүнд нь эгдүүцсэн Хятад улс тус бүс нутагт цэргийн хүчээ улам бэхжүүлэхийн зэрэгцээ шинэ гадаад паспорт дээрээ маргаантай арлуудыг өөрийн харьяанд оруулсан нь хоёр жилийн өмнө ихээхэн асуудал дагуулж вьетнамчуудын хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч байлаа.



БНХАУ, Японы маргаантай газар нутгууд

БНХАУ болон Японы хооронд Өмнөд Хятадын тэнгист байдаг Сэнкаку олтригийн бүлэг арлуудыг тойрсон маргаантай. Хоёр талаасаа үе үе тус арал дээр өөрсдийн улсын туг далбаагаа мандуулснаас болж, хоёр улсад нэгнийгээ эсэргүүцсэн жагсаал цуглаан болж, зарим нь бусдын эд зүйлс, бизнест хохирол учруулах үйлдлүүд хийсээр ирсэн. Иймэрхүү асуудлаас болоод хоёр улс хоорондоо эсэргүүцлийн ноот бичиг солилцохоос эхлээд заримдаа цэрэг, зэвсэг ч

Япончуудын Сенкакү гэдэг арлыг Америкчууд мэдэлдээ байлгаж байгаад 1971 онд Япончуудад өгсөн. Энэхүү арал нь бүр Японы хувь хүний эзэмшилд байдаг. Гэвч үүнийг нь Хятад хүлээн зөвшөөрөхийг огт хүсдэггүй. Эдгээр арлын орчмоос байгалийн хийн орд газар илэрсэн нь асуудлыг улам хурцатгадаг



БНХАУ, Энэтхэгийн маргаантай газар нутгууд
Хятад, Энэтхэг хоёр улс аль хэдийнээс л хил дагуух газар нутаг дээрээ маргалдсаар ирсэн. Тус хоёр улс газар нутгийн маргаанаас болж хэд хэдэн удаа зэвсэгт мөргөлдөөнд орж, 1961-1962 онд дайн хийсэн. Энэхүү маргааны гол учир нь Британийн колончлогчдын 1914 оны үед Энэтхэг, Хятадын хил орчимд татсан “Мак Махоны шугам” гэгчээс болдог байна.

Хятадууд “Энэ шугамыг татсанаараа энэтхэгчүүд анхнаасаа Хятадын мэдэлд байсан Өмнөд Төвдийн нутгийг авсан” гэж гомдоллодог. Энэхүү шугамын дагуу 700 км үргэлжилдэг нутгийг манайх гэж маргалдсаар ирсэн. Энэ нь 80 мянган км. кв нутаг дэвсгэр гэсэн үг ажээ. Энэтхэгийн Уттаракханд, Ладах, Араначал-Прадеш, Жамму, Кашмир зэрэг мужид Хятадууд үе үе нэвтэрдэг.

БНХАУ, Бутаны маргаантай газар нутгууд
Хятад, Энэтхэгийн дунд Гималайн уулс дунд оршдог Бутан улс нь газрын нутгийн хувьд жижигхэн. БНХАУ бутанд Хятадын 270 км.кв “нутаг” бий хэмээн шаарддаг байна. Бутан улс газар нутгаар жижиг болохоор ямар ч байсан газраа өгөх эрхгүй гэдэг ажээ. Тиймээс ч тус улс Хятадтай залгадаг хилээ хаан, өмнөд хөрш Энэтхэг улстай бүх талаар хамтран ажиллах бодлого хэрэгжүүлдэг байна.

===БНХАУ, Мьянмарын маргаантай газар нутгууд ===

БНХАУ-ын дөнгөж байгуулагдсаны дараа Ардын чөлөөлөх арми нь Бирмд үүрлэсэн Гоминданы үлдэгдлийг бут цохихоор тус улсын нутагт цөмрөн ороод буцаж гараагүй байна. Үүнийг Бирмийн эрх баригчид удаа дараа шаардсан боловч цэргээ гаргаагүй учир 1955 онд цэргийн хүчээр хөөн гаргахаар дайн хийжээ. Шинээр байгуулагдсан БНХАУ-ыг олон улсаар хүлээн зөвшөөрүүлэх зорилготой Хятадууд Бирмээс цэргээ гаргаж газар нутгийн шинэ хэлэлцээр байгуулжээ. Түүний дараа Хятад улс Бирмийн Качин хэмээх газрыг Өмнөд Төвдийн нэг хэсэг үзэж маргаан дэгдээж үүнийгээ одоо ч үргэлжлүүлж байна.

АНХААРАЛ ТАВЬСАНД
БАЯРЛАЛАА :)

